

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/65/НА-СТА-ТХН

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 51-261885 Цахим хаяг: <a href="mailto:khosjargalts@audit.gov.mn">khosjargalts@audit.gov.mn</a> Аудитор: С.Отгонхорлоо Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="mailto:otgonkhorloos@audit.gov.mn">otgonkhorloos@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: <a href="mailto:dabg.audit@gmail.com">dabg.audit@gmail.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ  
БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ  
Ц.БАЙГАЛМАА ТАНАА

2024.02.20 № 07/240  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны хооронд 2020 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан 20.0 сая ам долларын санхүүжилттэй хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийг 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжих байсан.

Төслийн нийт үйл ажиллагааны төсвийн 32.5 хувь буюу 19,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилттэй Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг сайжруулах хөтөлбөрийн “Бичил бизнес эрхлэгчдэд бичил зээл олгох, санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх” зорилт 2020-2023 онуудад хэрэгжээгүй байна.

Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хооронд 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр дамжуулан зээлдэх 132/01/207ХХҮЕГ/73 дугаартай гэрээ байгуулснаар 2024 онд “Бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлуулж, бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгохоор төлөвлөн төслийн үргэлжлэх хугацааг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилээр сунгасан байна.

Z:\Yawsan\_Bichig\2024\0220 SNAG-7.Docx

0001050448

## Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 36.0 хувь, санхүүжилтийн зарцуулалт 29,817,138.0 мянган төгрөг буюу 52.0 хувьтай, төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна.

Бичил бизнес эрхлэгчдэд олгох жижиг зээлийн эрэлт буурч, хөтөлбөр хэрэгжээгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Засгийн газраас 2021-2023 онд Ажлын байрыг дэмжих зорилготой, жилийн 3.0 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгосон;
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2022-2023 онд дамжуулан хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдэд хүүгүй, барьцаа хөрөнгө шаардахгүй 36 сарын хугацаатай, 10.0 сая хүртэлх төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.

## Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 33.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Улаанбаатар 2024 оны 10 сарын 22  
602367087

Z:\Yawsan\_Bichig\2024\0220 SNAG-7.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,530,535,183.16</b>	<b>7,073,169,359.99</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>2,528,535,183.16</b>	<b>7,059,083,178.36</b>
312	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>2,528,535,183.16</b>	<b>7,059,083,178.36</b>
3121	<b>Төгрөг</b>	<b>305,096,139.87</b>	<b>1,886,264,862.51</b>
31210	Төрийн сангийн харилцах	305,096,139.87	1,886,264,862.51
3122	<b>Гадаад валют</b>	<b>2,223,439,043.29</b>	<b>5,172,818,315.85</b>
31221	Төрийн сангийн харилцах	2,223,439,043.29	5,172,818,315.85
33	<b>Авлага</b>	-	<b>5,472,000.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	-	5,472,000.00
34	<b>Урьдчилгаа</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	2,000,000.00	2,000,000.00
35	<b>Бараа материал</b>	-	<b>6,614,181.63</b>
35410	Бичиг хэргийн материал	-	6,614,181.63
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	-	<b>127,768,167.15</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	-	<b>127,768,167.15</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	-	<b>120,078,666.95</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	131,727,272.73
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(71,352,272.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	87,500,454.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(47,307,337.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	42,842,819.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(23,332,268.99)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	-	<b>7,689,500.20</b>
39301	Програм хангамж	-	16,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(9,210,499.80)
2	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,530,535,183.16</b>	<b>7,200,937,527.14</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,126,000.00</b>	<b>6,916,790.70</b>
413	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>3,126,000.00</b>	<b>6,916,790.70</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	3,126,000.00	6,916,790.70
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,527,409,183.16</b>	<b>7,194,020,736.44</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,527,409,183.16</b>	<b>7,194,020,736.44</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,840,938,836.01	2,527,409,183.16
51220	Тайлант үеийн үр дүн	(313,529,652.85)	4,666,611,553.28
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,530,535,183.16</b>	<b>7,200,937,527.14</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>175,000.00</b>	<b>5,318,740,221.99</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>175,000.00</b>	<b>5,318,740,221.99</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>175,000.00</b>	<b>5,318,740,221.99</b>

1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	5,163,075,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	155,665,221.99
120009	Бусад орлого	175,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>698,284,860.13</b>	<b>638,536,202.77</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>247,744,786.90</b>	<b>638,536,202.77</b>
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	247,744,786.90	638,536,202.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	306,018,459.13
210101	Үндсэн цалин	-	306,018,459.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	37,859,738.10
210201	Тэтгэврийн даатгал	-	37,859,738.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	68,220,000.00
210304	Байрны түрээс	-	68,220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	9,303,266.08
210401	Бичиг хэрэг	-	2,925,509.94
210402	Тээвэр, шатахуун	-	863,636.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	5,514,119.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	247,744,786.90	189,237,684.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ	247,744,786.90	189,237,684.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	27,897,054.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	27,897,054.84
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>450,540,073.23</b>	<b>-</b>
221002	Тоног төхөөрөмж	450,540,073.23	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(698,109,860.13)</b>	<b>4,680,204,019.22</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>384,580,207.28</b>	<b>50,350,806.99</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	384,580,207.28	50,350,806.99
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>63,943,272.93</b>
225001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	-	63,943,272.93
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>384,580,207.28</b>	<b>(13,592,465.94)</b>
<b>7</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(313,529,652.85)</b>	<b>4,666,611,553.28</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	175,000.00	5,163,075,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000.00	5,163,075,000.00
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого	175,000.00	5,163,075,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	5,163,075,000.00
120009	Бусад орлого	175,000.00	-

2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>246,618,786.90</b>	<b>618,934,538.86</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>246,618,786.90</b>	<b>618,934,538.86</b>
210	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>246,618,786.90</b>	<b>618,934,538.86</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	<b>279,293,886.07</b>
210101	Үндсэн цалин	-	279,293,886.07
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>37,859,738.10</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	37,859,738.10
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>68,220,000.00</b>
210304	Байрны түрээс	-	68,220,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>9,303,266.08</b>
210401	Бичиг хэрэг	-	2,925,509.94
210402	Тээвэр, шатахуун	-	863,636.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	5,514,119.78
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал</b>	<b>246,618,786.90</b>	<b>224,257,648.61</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	246,618,786.90	224,257,648.61
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(246,443,786.90)</b>	<b>4,544,140,461.14</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
222001	Тоног төхөөрөмж	450,540,073.23	-
4	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>450,540,073.23</b>	-
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(450,540,073.23)</b>	-
6	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	384,580,207.28	50,350,806.99
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	-	63,943,272.93
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>384,580,207.28</b>	<b>(13,592,465.94)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(312,403,652.85)</b>	<b>4,530,547,995.2</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,840,938,836.01</b>	<b>2,528,535,183.16</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,528,535,183.16</b>	<b>7,059,083,178.36</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>2,840,938,836.01</b>	<b>2,840,938,836.01</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>2,840,938,836.01</b>	<b>2,840,938,836.01</b>
Тайлант үеийн үр дүн		(313,529,652.85)	(313,529,652.85)

<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>2,527,409,183.16</b>	<b>2,527,409,183.16</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>2,527,409,183.16</b>	<b>2,527,409,183.16</b>
Тайлант үеийн үр дүн		4,666,611,553.28	4,666,611,553.28
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>7,194,020,736.44</b>	<b>7,194,020,736.44</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,873,000,000.00</b>	<b>618,934,538.86</b>	<b>1,254,065,461.14</b>	<b>33.0</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>1,873,000,000.00</b>	<b>618,934,538.86</b>	<b>1,254,065,461.14</b>	<b>33.0</b>
210	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>1,873,000,000.00</b>	<b>618,934,538.86</b>	<b>1,254,065,461.14</b>	<b>33.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>370,000,000.00</b>	<b>279,293,886.07</b>	<b>90,706,113.93</b>	<b>75.5</b>
210101	Үндсэн цалин	370,000,000.00	279,293,886.07	90,706,113.93	75.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,000,000.00</b>	<b>37,859,738.10</b>	<b>12,140,261.90</b>	<b>75.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,000,000.00	37,859,738.10	12,140,261.90	75.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,000,000.00</b>	<b>68,220,000.00</b>	<b>9,780,000.00</b>	<b>87.5</b>
210304	Байрны түрээс	70,000,000.00	68,220,000.00	9,780,000.00	87.5
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,000,000.00</b>	<b>9,303,266.08</b>	<b>20,696,733.92</b>	<b>31.0</b>
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	2,925,509.94	3,074,490.06	48.8
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	863,636.36	2,736,363.64	24.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,400,000.00	5,514,119.78	14,885,880.22	27.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,345,000,000.00</b>	<b>224,257,648.61</b>	<b>1,120,742,351.39</b>	<b>16.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,345,000,000.00	224,257,648.61	1,120,742,351.39	16.7
1	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,873,000,000.00</b>	<b>5,163,075,000.00</b>	<b>(3,290,075,000.00)</b>	<b>275.7</b>
120	<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>1,873,000,000.00</b>	<b>5,163,075,000.00</b>	<b>(3,290,075,000.00)</b>	<b>275.7</b>
120044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,873,000,000.00	5,163,075,000.00	(3,290,075,000.00)	275.7
3	Тохируулсан орлогын дүн		(13,592,465.94)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,528,535,183.16		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,059,083,178.36		
61	<b>Байгууллагын тоо</b>	<b>1</b>	<b>1</b>	-	
62	<b>Ажиллагсадын тоо</b>	<b>8</b>	<b>8</b>	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.0

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илэрээгүй.

Аудитаар нийт 2,326.6 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 2,326.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
1	Тайлант оны эцэст төслийн санхүүжилтийн нийт зарцуулалт 29,817,138.0 мянган төгрөг буюу 52.0 хувьтай, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 36.0 хувьтай байна. Үүнд: "Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр" хэрэгжээгүй, тайлант оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 33 худалдан авалт хийхээр төлөвлөснөөс 4 худалдан авалт хийж, гүйцэтгэл 4.0 хувьтай байгаа нь төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнд нөлөөлсөн байна.	1	-			1	-								
2	Тайлант онд 3 аж ахуйн нэгжээс 2,326.6 мянган төгрөгийн ажил үйлчилгээг худалдан авахдаа нэмэгдсэн өртгийн албан татварын цахим баримтыг бүрдүүлээгүй байна.	1	2,326.6					1	2,326.6						
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,326.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2,326.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрсэнээс зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Төслийн нэгж нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 156 мэдээллээс 153 мэдээлэл хугацаанд нь байршуулж, Дараа жилийн төсвийн төсөл гэсэн 1 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш нийт 25 мэдээллийг бүрэн байршуулсан байна.	1	-			1	-
<b>Дүн</b>	1	-	-	-	1	-